



ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

2025.05.07

ОРХОН АЙМАГ

НЭГ. Шалгалтын үндэслэл, зорилго

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газрын даргаас 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн албан бичгээр иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга, шийдвэрлэлтийн байдал, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг шалгаж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ боловсруулахад оршино.

ХОЁР. Шалгалтын бүрэлдэхүүн, хамрах хугацаа

Захиргаа, хяналтын хэлтсийн дарга Г.Галбадрах нь 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хугацааны өргөдөл, гомдол шийдвэрлэсэн байдалд хяналт шалгалт хийсэн.

ГУРАВ. Шалгалтын дүнгийн талаар

Шалгалтын талаар:

Тухайн хугацаанд 11-11 төвөөр 9, бичгээр 29 нийт 38 гомдол хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг өгч ажилласан байна. Өргөдөл, гомдлыг Эрдэнэт И-Оффис цахим системд болон бүртгэлийн дэвтэрт бүртгэж шийдвэрлэлтийн талаарх тэмдэглэлийг хөтөлсөн байна.

Албан хэрэг хөтлөлтийн ажилтныг 2024 оны 06 дугаар сарын 04-ны өдөр томилон ажиллуулсан. Архивын ерөнхий газрын 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн хооронд дахь 30 хоногийн хугацаанд “Архив, албан хэрэг хөтлөлт”-ийн сургалтад хамрагдан, мэргэжил эзэмшин үнэмлэх авсан байна.

№	Шийдвэрлэлтийн байдал	Нийт өргөдөл гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь	
		Тоо	Хувь
1	Нийт хүлээн авсан өргөдөл, гомдол	38	100 %
2	Хугацаанд нь шийдвэрлэсэн	37	97,36 %
3	Хугацаа хэтэрсэн	0	0 %
4	Хариу өгөөгүй, бүртгэлгүй	0	0 %
5	Давтан гомдол	1	2,63 %



Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой 1 иргэн өмнө нь хандаж байсан асуудлаар өргөдөл, гомдол дахин 1 удаа гаргасан байна.

№	Агуулга	Нийт өргөдөл гомдлын тоо, эзлэх хувь	
		Тоо	Хувь
1	Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, шимтгэл төлөлт болон нөхөн төлүүлэхтэй холбоотой	4	10.53%
2	Тэтгэврийн тогтоолт, олголт, өөрчлөлттэй холбоотой	9	23.68%
3	Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн тогтоолт, олголттой холбоотой	5	13.16%
4	Ажилгүйдлийн тэтгэмж тогтоолт, олголттой холбоотой	6	15.79%
5	Овог нэр, регистрийн дугаарын өөрчлөлт, регистрийн дугаар нэгтгэхтэй холбоотой	7	18.42%
6	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаатай холбоотой	7	18.42%
НИЙТ		38	100%

Нийт гомдлын 52,63 % нь тэтгэвэр болон тэтгэмж тогтоолт, олголт, өөрчлөлттэй холбоотой асуудлаар ирүүлсэн нь шинэ SICOS программ нэвтрүүлсэн, санхүүжилт хүрэхгүй байдлаас шалтгаалсан байна.

ДҮГНЭЛТ

Бичиг хэргийн ажилтны мэдлэг, чадварыг сайжруулахад анхаарч сургалтад хамруулж, өргөдөл гомдлоо цахим систем болон цаасаар дарааллын дагуу бүртгэж, хуулийн хугацаанд шийдвэрлэж 34 утсаар, 4 биечлэн хариуг өгч ажилласан байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг сар бүр гаргаж, ил тод болгож олон нийтэд цахим хуудсаар болон мэдээллийн самбарт байршуулан мэдээлсэн байна.

Алдаа, зөрчил:

Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд хандаж буй 18 өргөдөл, гомдлын бүртгэлийг тусдаа хөтөлж, нэгдсэн бүртгэлд оруулаагүй байна. Тухайн хугацаанд ирсэн нийт 38 өргөдлөөс 11 гомдлын шийдвэрлэсэн байдлын утга товчхон, холбогдох хуулийн заалтыг бичээгүй хаасан байна.

Цаашид анхаарах асуудлууд:

1. Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж байгаа ч, шийдвэрлэлтийн дундаж хугацааг багасгах



2. Шийдвэрлэлтийн талаарх тэмдэглэлийг хөтлөхдөө шийдвэрлэсэн гол утга санаа, шийдвэрлэсэн хуулийн заалтыг тодорхой бичиж хаах
3. Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд ирүүлж буй өргөдөл, гомдлыг нэгдсэн бүртгэл оруулан бүртгэж, шийдвэрлэлтийг хааж ажиллах

ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТЭС

